

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 09 дүгээр сарын 25

Дуурсах

Тус газар нь 2017 оны 3 дугаар улиралд Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийг хангах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлын үр нөлөөг сайжруулах, алба хаагчдын шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй түргэн шуурхай үйлчлэх, албаны бэлэн байдал, мэргэжлийн ур чадвараа сайжруулахад онцгой анхаарч, Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль, тушаал заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан.

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаагийн байгууллагаас 2017 онд дэвшүүлсэн зорилтыг мөрдлөг болгон, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газраас гаргасан Цагдаагийн байгууллагатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг тасаг, хэсгийн дарга, ахлах нарт болон бие бүрэлдэхүүнд цаг тухай бүрт нь хүргэж, шаардлагатай тохиолдолд үүрэг даалгавар, шийдвэрийн талаар сургалт зохион байгуулан Цагдаагийн байгууллагад холбогдох үндэсний хөтөлбөр, дээд газраас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр тус бүр 5-32 ажил, арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөнүүдийг тус тус гарган, биелэлтийг улирал, хагас жилээр тооцон ЦЕГ-ын холбогдох албадад хүргүүлж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлын 2, 3 дугаар улирлын төлөвлөгөөний биелэлтийг хангуулан ажилласан.

Аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Цагдаагийн газарт хамаарах болон аймгийн Засаг даргаас Цагдаагийн газрын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр 8-26 заалт бүхий төлөвлөгөө гарган батлуулж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой ажил арга хэмжээг төлөвлөн биелэлтийг тооцон ажилласан.

2017 оны эхний 9 сард газрын даргын зөвлөл 18 удаа хуралдаж үйл ажиллагааны чиглэлээр 18, хүний нөөцийн чиглэлээр 50, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 34, бусад асуудлын талаар 18 нийт 120 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу албан тушаал дэвшүүлэх, өөрчлөх саналтай 34, данс бүртгэлээс хасуулж, тэтгэмж олгуулах 1, тэтгэвэрт гаргаж, тэтгэмж олгуулах 1, Улаанбаатар хот руу шилжүүлэх 3, цагдаагийн албанаас түр чөлөөлөх 1 алба хаагчийн материалыг харъяа албадаар нь дамжуулан шийдүүлж, ХСИС-ийн эчнээ 3 жилийн хөтөлбөрийн сургалтад хамрагдах хүсэлт гаргасан 7, энхийг сахиулах ажиллагаанд оролцох сонгон шалгаруулалтад хамрагдах хүсэлт гаргасан 1, мөнгөн урамшил олгох 1, Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын академийн элсэлтийн шалгалтад хамрагдах хүсэлт гаргасан 1, офицер албан тушаал /ажлын байр/-ын сургалтад хамруулах 1, офицерын бүрэлдэхүүнд оруулах болон хугацааны цолоор шагнуулах 22, ЦЕГ-ын “Албаны төлөө” I, II, III зэргийн медалиар шагнуулах 32, Төрийн, ХЗДХС, ЦЕГ, бусад шагналаар шагнуулах 41 алба хаагчийн материалыг хүргүүлсэн байна.

Тус газрын орон тоо нь ЦЕГ-ын даргын 2017 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан офицер 71, ахлагч 65, энгийн 3, гэрээт цагдаа 4 нийт 143 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны эхний 9 сард офицер 71, ахлагч 64, энгийн 3, Монголбанкны гэрээт 4, нийт 142 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа. Батлагдсан орон тооноос харуулын цагдаагийн 1 орон тоо дутуу байна.

Тус газрын сул орон тоог нөхөх нөөц бүрдүүлэх зорилгоор нягтлан бодогч, харуулын цагдаа, хэв журмын цагдаа, цагдаа-жолоочийн орон тоог нээлттэй зарлуулах захиалгыг 2017 оны 03 дугаар сард ЦЕГ-ын ХНСХ-т хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлөөс цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тоог иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулах замаар нөхөх мэргэшлийн шалгалтыг 2017 оны 09 дүгээр сарын 04-09-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдахаар болсонтой холбогдуулан зарлагдсан орон тоонд өрсөлдөх хүсэлт гаргасан 27 иргэний материалын хүлээн авч холбогдох хүний нөөцийн судалгааг явуулан, Цагдаагийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2, ЦЕГ-ын даргын 2015 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалд томилох, болзол, шаардлага, шалгуур” /код 901/-д заасан болзол шаардлагыг хангасан 16 иргэний материалыг журмын дагуу бүрдүүлж, ЦЕГ-ын ХНСХ-т хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу ахлагчийн сул орон тоонд өрсөлдүүлэн сонгон авах мэргэшлийн шалгалтад хамруулан, Төрийн албаны салбар зөвлөлийн 2017 оны 12 дугаар тогтоолоор 6 иргэн нөөцөд бүртгэгдсэн.

ЦЕГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн б/177 дугаар тушаалаар Жаргалант сум дахь Сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Д.Галбадрах нь өвчний учир нас барсан тул данс бүртгэлээс хасаж, ЦЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн б/235 дугаар тушаалаар 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг охин Г.Соёлмаад олгохоор шийдвэрлэсэн.

Тус газраас ЦЕГ-ын даргын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 36/280 дугаартай албан бичгээр өгсөн ажлын чиглэлийн дагуу хүний нөөцийн нэгдсэн санд “Хүний нөөцийн цахим санг ашиглах, түүний аюулгүй байдлыг хангах журам /код 949.5”-д заасны дагуу цахим санд оруулсан 142 алба хаагчийн мэдээлэл үнэн бодитой эсэхэд тулгалт хийж, алдаатай оруулсан 1136 мэдээллийг засварлаж, дутуу оруулсан 931 мэдээллийг шинээр шивж, албаны болон хувийн мэдээллийн баяжилт хийж, офицер 61 алба хаагчийн 1140 хуудас, ахлагч 58 алба хаагчийн 1305 хуудас материалыг хувийн хэрэгт баяжилтыг хийсэн.

Тус газраас 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг сар, улирал, жилээр төлөвлөн баталгаажуулж, сар бүрийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг тооцон, аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлж хэвшсэн. Тухай сарын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан дараа сард хийж хэрэгжүүлэх ажлаа оновчтой төлөвлөж, хэрэгжилтийг сар бүр газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж ажилласан.

Байгууллага, алба хаагчийн өдөр тутмын ажилд дотоодын хяналтыг тавих, шинэчлэн батлагдсан хууль, дүрэм, журамд нийцүүлэн цагдаагийн албан хаагчийн ёс зүйн шаардлага, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлыг таслан зогсоох зорилгоор байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргаас өгсөн ажлын чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 11 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсгээс сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг шалган зааварчлах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тус газраас 2016 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг сэтгүүл хэлбэрээр 1000 ширхэг хэвлүүлэн, бүх сумдын иргэний танхим болон тайлангийн хурал, “Нээлттэй хаалганы өдөр”-ийн үеэр иргэдэд тарааж сурталчилан, тайланг бүрэн эхээр нь цахим сайтад байршуулсан. 2017 оны 1 улирал, эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Тэмүжин театрт 2 удаа, хэсгийн 9 байцаагч нараас тухайн багийн иргэдэд тус бүр 1 удаа, 19 суманд тус бүр 1 удаа нийт 30 удаа иргэдэд тайлагнаж, 3 дугаар улирлын тайлангийн хурлыг 10 дугаар сарын эхний 7 хоногт хийхээр төлөвлөсөн.

Тасгийн дарга, ахлах байцаагч нараас хариуцсан алба хаагч нарын ажлыг өдөр тутам шалгаж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр гаргасан зөрчил дутагдал, ЭБШХ зөрчсөнтэй холбогдуулан ирүүлсэн прокурорын шаардлагуудын шалтгаан нөхцөлийг судлан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдад танилцуулж, 6 удаа 12 цагийн сургалт орж, бичгээр 11 зааварчилгаа өгсөн. Зөрчил гаргасан болон гаргаж болзошгүй 39 алба хаагчдад “Сануулах хуудас” өгч дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллах талаар баталгаа авсан.

Эрх бүхий албан тушаалтнаас Саатуулах байрны эмч цагдаа, жижүүрийн шуурхай алба, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт давхардсан тоогоор 78 ажлын зааварчилгаа өгч, өдөр тутам үүрэг, ажлын чиглэл өгч биелэлт үр дүнг тооцов.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаатай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газраас боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, үйл ажиллагааны журам, танилцуулга нийт 16-ийг алба хаагчдад танилцуулан, гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж холбогдох албадад хүргүүлсэн.

ЦЕГ-ын “Сургагч багш”-ийн сургалтад хамрагдсан 2 алба хаагчаас шинээр батлагдан гарсан, өөрчлөлт орсон хуулийн талаар 7 удаа сургалт зохион байгуулж алба хаагчдын мэдлэгийг шалгах зорилгоор Цагдаагийн албаны хуулиар нийт 120 асуулт бүхий тестээр 3 удаа шалгалт авч, үр дүнг тооцон газрын даргын танилцуулж, холбогдох хуулиудыг судлаж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах талаар удирдлагаас 2 удаа үүрэг, ажлын чиглэл өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан шинээр батлагдсан хуулиудыг таниулах, сурталчлах 5 өдрийн сургалтад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий бүх алба хаагчдыг бүрэн хамруулж, гарын авлага, материалаар хангасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг гардан авах, цагдаагийн тангараг өргөх ёслолын ажиллагааг энэ оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 11 цаг 40 минутад аймгийн төвийн “Баганат” талбайд зохион байгуулж, аймгийн удирдлагууд болон хууль хяналтын тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын удирдлага, албан хаагч, иргэд, цагдаагийн газарт ажиллаж байсан үе үеийн ахмадууд ирж оролцсон. Арга хэмжээний талаарх мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилан ажилласан.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажилладаг тусгайлсан чиг үүрэг бүхий хууль хяналтын болон төрийн захиргааны 12 байгууллагуудтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулж, биелэлтийг хагас жилээр тооцсон.

Тус газраас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Боловсрол соёлын газартай хамтран "Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүрийн оролцоо" сэдэвт 3 өдрийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Осол гэмтлээс сэргийлэх хүүхдийн түлэгдэл, эцэг эхийн хариуцлага” сэдэвт аяны хүрээнд тус газраас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, түүнтэй холбогдож нэмэлт өөрчлөлт орсон хуулиудыг сурталчлах, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг зөрчлийн тоон мэдээ шалтгаан нөхцөл сэдвээр сургалт зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулиудын удирдлагууд, нийгмийн ажилтан нартай байнгын холбоотой ажиллаж, 6 ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэр бүлийн хүчирхийлэл, согтууруулах ундаа, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, уршгийн талаарх сургалтыг Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, сургуулийн нийгмийн ажилтан нартай хамтран давхардсан тоогоор нийт 960 сурагчдад 4 удаагийн сургалт, мэдээллийг хийсэн.

Хүүхдийг аливаа эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сургуулийн цагдаа” эргүүлийн журмыг боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан тогтоол гаргуулж, сургуулиудын орчинд эцэг, эхчүүдийг эргүүлд гарган ажиллуулснаар тухайн газарт гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй.

Тус газарт иргэдээс цагдаагийн албан тушаалтанд хандан ажилд орох болон суралцахыг хүссэн 17, цагдаагийн байгууллагад ажиллаж байсан иргэн ажилд дахин орохыг хүссэн 5, алба хаагчдаас ажлын байраа өөрчлөх, шилжин ажиллахыг хүссэн 50, захиргааны чөлөө хүссэн 61, орон сууцанд орохыг хүссэн 16, тэтгэвэрт гарахыг хүссэн 1, архивын лавлагаа авахыг хүссэн 1, бусад 90 нийт 241 өргөдөл, гомдол ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж өргөдөл, гомдлын үлдэгдэлгүй байна.

Тус Цагдаагийн газар үүсч хөгжсөний түүхт 75 жилийн ойг угтаж, хамт олны хурлыг зохион байгуулан “Бүтээлч ажил-75” аяныг өрнүүлэн, алба хаагчдаас ойн хүрээнд хийх ажлын саналыг нэгтгэн хийх ажил, хугацаа, хариуцах эзэн зэргийг тодорхойлон төлөвлөж, 75 ажил арга хэмжээний жагсаалтыг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан. Зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаарх зурагт мэдээлэл, илтгэх хуудсыг тухай бүр нь холбогдох алба хаагчдаас авч, хавтас нээн баяжуулан, байгууллагын цахим сайт болон орон нутгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажилласан.

Газрын даргын 2015 оны А/10 дугаар тушаалаар байгуулагдсан криминологи судалгааны багийг гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийлгэж, криминологи судалгааны багийг 6 удаа хэсгийн байцаагч, багийн цагдаа, эрүүгийн төлөөлөгч нарыг оролцуулан хуралдуулж, өргөтгөсөн байдлаар газрын даргын зөвлөлийн хурлаар 1 удаа нийт 7 удаа хуралдуулж, шийдвэр гарган түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулан ажилласан.

Сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зам тээврийн осол, хэрэг өсч байгаа шалтгаан нөхцлийг судлан Цагдаагийн газрын криминологи судалгааны багаар хэлэлцүүлэн дүн шинжилгээ хийлгэж, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт “Зөвлөмж” хүргүүлсэн.

Энэ оны эхний 9 сарын байдлаар сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг тус байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүд 2 удаа зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 6 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Байгууллагын тасаг, хэсгийн дарга нараас сар бүр алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх ажлын хүрээнд тус бүр нэг шинэ ажил, арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчдыг гэр бүлийн гишүүдийн хамт оролцуулсан хамт олны уур амьсгалыг бэхжүүлэхэд үр дүнгээ өгсөн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нээлттэй өдөр” арга хэмжээг аймгийн хэмжээнд 3 удаа, газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс 19 сумдад тус бүр 2 удаа зохион байгуулж, тус газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан болон энэ онд Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа арга

хэмжээний талаар иргэдэд сурталчилан, гарын авлага 3220 ширхэгийг тарааж, энэ талаарх мэдээллийг байгууллагын сайт, цахим хуудас болон орон нутгийн 2 телевизээр сурталчилсан.

Тус газар нь улсын хэмжээний 12, цагдаагийн газрын хэмжээнд 14 нэгдсэн арга хэмжээ, 38 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 71 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтад гарч ажилласан ба 141 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 210 удаа уулзалт ярилцлага, 30 удаагийн өдөрлөг, 5 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулж, нийт 257 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18870 иргэнийг хамруулж ажилласан. Дээрх арга хэмжээнд 2150 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, 1520 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 830 малчин, 240 оюутан, 10890 сурагч, 3240 ажилгүй иргэд хамрагдсан ба 186 аж ахуй нэгж байгууллагаас давхардсан тоогоор 124 төрийн байгууллага, 8 аж ахуй нэгж, 10 их дээд сургууль, коллеж, 42 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгаас Нийтийн хэв журам хамгаалах тасаг, хэсгийн төлөөлөгч нарыг хамруулан “Мэдэгдэл”, “Сар шинэ-2017”, “Объектын судалгаа”, “Тээврийн хэрэгслийн өнгө үзэмж”, “Хүүхдийг осол хэргээс урьдчилан сэргийлэх аян”, “Хөдөлгөөнт эргүүлүүд”, “Түдгэлзүүлсэн хэрэг-Оргодол”, “Цахим тоглоом”, “Өсвөрийн цагдаа” гэх зэрэг 147 удаагийн ерөнхий болон тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр иргэдэд сурталчилж, мэдээлэл хүргэсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт 147 аж ахуйн нэгж, байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж, албан мэдэгдлийн хариуг авах, үр дүнг тооцох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хэсгийн байцаагч, багийн цагдаа нарт үүрэг чиглэл өгч ажиллуулснаар 141 мэдэгдлийн хариуг авсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Баянхонгор”, “Хонгор”, “Мазаалай”, аймгийн хэвлэл мэдээллийн алба зэрэг телевизүүдэд долоо хоног бүр мэдээлэл хийж, үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 34 удаа 8 цагийн ярилцлага өгч, иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлгийг өгч, хууль сурталчилсан.

Тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр 36 байгууллагын 180 алба хаагчийг “Нийтийн эргүүл”-д ажиллуулж, аж ахуй нэгж, байгууллага, иргэн, тээврийн хэрэгсэлд цагдаагийн албан хаагчидтай хамтран давхардсан тоогоор 424 аж ахуй нэгж байгууллага, 650 иргэн, 983 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг явуулсан. Нийтийн эргүүлд гарч ажилласан, иргэний нийгмийн байгууллагуудын ажилтан нар эргүүлд гарах хугацаанд архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, цагийн хуваарь зөрчиж үйл ажиллагаа явуулсан 7 зөрчил, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 39, гудамж талбайд хэвийн явсан 52 зөрчлийг илрүүлэн хариуцлага тооцон ажилласан.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр оройн эргүүлд гарч байгаа эргүүлийн алба хаагчид болон баг хариуцсан хэсгийн байцаагч, багийн цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нарт үүрэг чиглэл өгч, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад 19 удаагийн мэдээлэл, ярилцлага өгч иргэдэд

анхааруулга, сэрэмжлүүлэг өгч ажиллуулснаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 12 хувиар буурсан.

Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн төвд 3 удаа, 9 багийн иргэдэд тус бүр 1 удаа, 19 сумдад хууль сурталчлах “Нээлттэй өдөрлөг” аяныг зохион байгуулж, 5260 иргэдэд яриа ухуулга хийж, үйл ажиллагаагаа сурталчилж ажилласан.

Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллах чиг үүрэг бүхий 28 олон нийтийн цагдаагийн урамшууллын зардалд 100.008.000 төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн.

Тус газраас аймгийн Иргэний зөвлөлийн дарга, гишүүдийг 2016, 2017 оны 1 дүгээр улирал, хагас жилийн тайлангийн хуралд оролцуулан санал, хүсэлтийг нь сонсож, цагдаагийн байгууллагад тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээлэл солилцсон. Иргэний зөвлөлийн гишүүдийг солихоор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас сонгон шалгаруулалт зарласан ба ажлын хэсэгт Цагдаагийн газрын дарга оролцож, санал бодлоо тусгаж, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 30 дугаар тогтоолоор Иргэний зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилсон. Иргэний зөвлөлийн гишүүдээс 19 сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын амьдрал ахуйтай танилцаж, байгууллагад ашиглагдаж байгаа цагдаагийн бичил /кабон/байрны засвар, үйлчилгээтэй танилцаж, алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах, байрны засвар үйлчилгээг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон 6 сумдын Засаг дарга нарт хүсэлт хүргүүлж, 3 алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангасан.

Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргаас өгсөн ажлын чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 11 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган ажлын хэсгээс сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлыг шалган зааварчлах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сумдын иргэдэд Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайланг тайлагнах чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу 19 сумын 3150 иргэнд сонсож, иргэдээс гаргасан 12 санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, бүрэн шийдвэрлэн хариу өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэн, таслан зогсоох чиглэлээр алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургагч багшаас болон Гэр бүл, хүүхдийн хөгжлийн хэлтсийн 2 албан тушаалтанг урьж, нийт алба хаагчдад 4 удаа 6 цагийн сургалт зохион байгуулсан.

Тус газраас санаачлан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хууль эрх зүйн хэлтэс, Боловсрол соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн ЗӨН ОНХХ 1,2 зэрэг байгууллагуудтай хамтран “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хүн бүрийн оролцоо, хуулиа дээдлэе” аяны хүрээнд 19 сум, 9 багийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сумын нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, эцэг, эхийн төлөөлөл оролцсон зөвлөгөөнийг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ийн Хүүхдийн сан, Дэлхийн зөн ОНХХ 1,2

байгууллагуудтай хамтран Баянхонгор аймгийн хамтарсан багийг чадавхжуулах сум, багт ажиллаж байгаа хамтарсан багийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн ойлголт өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой “Хүүхдийн төлөө хамтдаа” хоёрдугаар чуулганыг амжилттай зохион байгуулж ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 82 этгээдүүдийн судалгааг хэсгийн байцаагч нараар гаргуулан 1 удаа 4 цагийн сургалтыг зохион байгуулж ажиллав. Тус газраас аймгийн Прокурорын газартай хамтран Баянхонгор аймгийн хэмжээнд захиргааны хяналтанд байгаа 96 ялтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх баталгаа авсан. Захиргааны хяналтын материалын бүрдлийг хангуулах чиглэлээр аймгийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран “Хорихоос өөр төрийн ял эдлүүлэх ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл” сэдэвт зөвлөгөөн зохион байгуулж, хэрэгжихэд хүндрэлтэй асуудлыг талаар санал солилцож, зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэн захиргааны хяналтанд байгаа ялтнуудын хувийн хэргийн бүрдлийг Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 дугаар тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”-ын дагуу хангуулж, 9 удаа зөрчил дутагдалгүй хянуулж ажилласан.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажил, дотоод бичиг баримт, объектын судалгаа, бүртгэл, эрүү, хэв журам, замын хөдөлгөөний болон ГА-ын нөхцөл байдлыг судлах, гэмт хэрэг, зөрчил илрүүлэхэд хэрхэн ашиглах талаар 8 удаа 32 цагийн сургалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Түдгэлзүүлсэн болон бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх зорилгоор “Гүйцэтгэх ажил явуулах /код 307/-журам”-ын 307.5.2 дахь хэсэгт зааснаар тус газрын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдаас 283 мэдээ, мэдээлэл авч, эрүүгийн цагдаагийн тасгаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 115 материал ирүүлсний 63 материалд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. ЦБҮАЖ код-307.5.2 д заасны дагуу гэмт хэрэг, оргон зайлсан сэжигтэн, яллагдагчийг олж тогтоох чиглэлээр нийт алба хаагчдаас сард 1 удаа үнэн бодитой шаардлага хангасан илтгэх хуудас, мэдээ мэдээлэл авч, эрүүгийн цагдаагийн тасагт танилцуулж шийдвэрлүүлж байгаа нь гэмт хэрэг, зөрчил илрүүлэхэд үр дүнгээ өгсөн.

2017 оны 3 дугаар улиралд гэмт хэргийн шинжтэй 134 мэдээ, мэдээлэл авч хэргийн газарт очиж ажилласнаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 24, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хэргээс илрүүлж, Мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн 4, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 74, одоо шалгаж байгаа үлдэгдэл 32 материалыг шалгаж байна.

Тайлант хугацаанд тасгийн алба хаагчдаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасагт 150 холбогдогчтой 209,6 сая төгрөгийн хохиролтой 88 хэрэг, нөхөн илрүүлсэн хэргийг шалгуулахаар 21 материал нийт 109 материалаар 132 хэрэг, үйлдэл илрүүлэн шилжүүлсэн. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас нийт 26 даалгавар, тогтоол хүлээн авч 24 даалгавар, тогтоолын хариуг өгч, 2 даалгавар, тогтоолын үлдэгдэлтэй байна.

Тус газраас гэмт хэргийн илрүүлэлт, хүн, эд зүйл, оргодол этгээдүүдийг эрэн сурвалжлах ажлын илрүүлэлтийг ахиулах чиглэлээр мөрдөгч, хэсгийн байцаагч, багийн цагдаа нарыг газрын даргын тушаалаар баг болгон хуваарилж Улаанбаатар хотруу 6 удаа 14 алба хаагчийг явуулан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан оргодол 8, гэмт хэрэгт сэрдэгдсэн 14 этгээдийг эрэн сурвалжлах ASAP санд оруулан эрэн сурвалжлах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулан ажилласны үр дүнд оргодол 7, гэмт хэрэгт сэрдэгдсэн 12 этгээдийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоон холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгч, одоо оргодол 1, гэмт хэрэгт сэрдэгдсэн 2 этгээдийг эрэн сурвалжилж байна. Тус газраас 2017 оны эхний 9 сарын байдлаар гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан оргодол, гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлийг шуурхай эрэн сурвалжилж олж тогтоон хэргийн илрүүлэлтийг ахиулах зорилгоор Эрэн сурвалжлах ASAP санд нийт 72 хүн, мал, эд зүйлийг оруулан эрэн сурвалжлалт зарлан ажилласнаас 32 хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтийг зогсоосон нь урьд оны мөн үетэй харьцуулахад 4 хувиар өссөн.

Мөрдөн байцаалтын чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 464, урьд оны үлдэгдэл 22 гомдол, мэдээлэл нийт 486 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 202 буюу 41.5 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 258 буюу 53.0 хувийг нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гарган прокурорт шилжүүлж, 17 буюу 3.4 хувийг нь харъяаллын дагуу шилжүүлж, одоо 23 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд 202 хэрэгт шинээр прокурорын газраас дугаар авч, урьд оны үлдэгдэл 9 хэрэг, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар шилжүүлснээс эрүүгийн хэрэг үүсгэн ирүүлсэн 13 хэрэг, урд оны дугаартай түдгэлзүүлснээс сэргээсэн 9 хэрэг, бусад байдлаар хүлээн авсан 32 хэрэг, хэрэгсэхгүй болсоноос сэргээсэн 2 хэрэг нийт 267 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 267 эрүүгийн хэргээс яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 130 хэрэг, хэрэгсэхгүй болгох саналтай 6 хэрэг, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай 16 хэрэг, харъяаллын дагуу 17 хэрэг тус тус прокурорт шилжүүлж, 18 хэргийг нэгтгэн шалгаж, ЭБШХ-д /хуучнаар/ заасан үндэслэл журмын дагуу ажиллагааны явцад шалгаж байсан 12 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэн одоо 68 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь мөрдсөн хэргийнхээ 74.5 хувийг нь шийдвэрлэсэн байна.

Тухайн онд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 267 хэргээс 2 хэргийн мөрдөн байцаалтын хугацааг сунган шалгаж 99.2 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн байна.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар прокуророос 1 хэрэг, шүүхээс 7 хэрэгт нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаасныг шалгаж шийдвэрлэн 8 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар шийдвэрлэн одоо нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаасан хэрэг байхгүй байна.

Гэмт хэрэгт холбогдсон 16 эрүүгийн хэрэгт 20 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч шалгаснаас одоо хорьж мөрдөн хугацаа сунган шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч байхгүй байна.

Шийдсэн хэргээс яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явуулсан 130 хэрэгт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож арилгуулахаар мөрдөн байцаагчийн мэдэгдэл хүргүүлж 95 мэдэгдлийн хариуг авч ажилласан.

Мөрдөн байцаах тасаг нь бусад тасаг албадтай хамтран аймгийн хэмжээнд “САР ШИНЭ”, “Шийдвэрлэлт-2017” зэрэг нэгдсэн 5 арга хэмжээг зохион байгуулан, Прокурорын байгууллагатай хамтарсан түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлж, шийдвэрлэх аяны хүрээнд салбар төлөвлөгөө гарган газрын даргын тушаалаар хуваарилсан 6 багт түдгэлзүүлсэн хэргүүдийг өгч, хамтран ажиллуулснаар урьд оны дугаартай 15 хэрэг, энэ оны дугаартай 1 хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг сэргээн шалгаж 1 хэргийг нөхөн илрүүлж, 1 оргодол, 2 сэрдэгдсэн этгээдийг олж тогтоон хэргүүдийг шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 903 гомдол, мэдээлэл, урьд оны үлдэгдэл 15 гомдол мэдээлэл, нийт 918 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 155 гомдолд зөрчлийн хэрэг нээн холбогдох ажиллагаануудыг хийн материалыг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлж, 556 гомдлыг хялбаршуулан 298 холбогдогчид 123.061.250 төгрөгийн торгууль оногдуулж, 21 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар шүүхээр баривчлуулж, 252 иргэнийг 1 жилийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 154 гомдол, мэдээллийг зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзаж, материалуудыг прокурорын хяналтанд шилжүүлж, 38 гомдол, мэдээллийг бусад байгууллага, тасагт харъяаллын дагуу шилжүүлэн 15 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Нийт шалгасан гомдол мэдээллийн 72.8 хувийг нь хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэн, гэмт хэргийн тухай 135 гомдол мэдээлэлд шинээр прокурорын газраас дугаар авч, урд оны үлдэгдэл 1 хэрэг, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтайгаар шилжүүлснээс эрүүгийн хэрэг үүсгэн ирүүлсэн 7 хэрэг бусад байдлаар хүлээн авсан 8 хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 4 хэрэг нийт 155 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан.

Эрүүгийн хэрэг үүсгэсэн, бусад байдлаар хүлээн авч шалгасан 118 хэргээс бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд нь тогтоогдоогүй 19 хэрэг

бүртгэгдсэний 12 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоон хэргийн илрүүлэлт 65.2% хувьтай.

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хэрэг бүртгэх эрх бүхий алба хаагч нарт мэдлэг, чадвар эзэмшүүлэх, хуульч ажиллагааг хангаж, иргэдийг чирэгдүүлэхгүй, шуурхай ажиллах зорилт тавин ажилласаны үр дүнд шалгаж шийдвэрлэсэн 105 хэргээс 56 хэрэг буюу 57.9 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн.

Энэ оны эхний 8 сард тус газарт нийт 2278 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 158 нэгжээр буюу 6,4 хувиар буурсан байна. Үүнээс 772 буюу 33 хувийг гэмт хэргийн шинжтэй, 1577 буюу 69 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 290 буюу 37 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 458 буюу 59 хувийг нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлэн шийдвэрлэж, 1577 гомдол, мэдээлэлд захиргааны арга хэмжээ авч, нийт шалгасан гомдол, мэдээллийн 51 хувийг хуулийн анхны хугацаа буюу 5 хоногт шалгаж шийдвэрлэсэн.

Гэмт хэрэгт холбогдсон 16 эрүүгийн хэрэгт 19 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч шалгаснаас одоо хорьж мөрдөн хугацаа сунган шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч байхгүй.

Шийдсэн хэргээс яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явуулсан 98 хэрэгт гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож арилгуулахаар мэдэгдэл хүргүүлж, 69 мэдэгдлийн хариуг авч ажилласан.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасаг нь бусад тасаг, хэсэгтэй хамтран түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлж, шийдвэрлэх аяны хүрээнд салбар төлөвлөгөө гарган газрын даргын тушаалаар хуваарилсан 6 багт түдгэлзүүлсэн хэргүүдийг өгч, хамтран ажиллуулснаар урьд оны дугаартай 18 хэрэг, энэ оны дугаартай 2 хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг сэргээн шалгаж 2 хэргийг нөхөн илрүүлж, 1 оргодол, 2 сэрдэгдсэн этгээдийг олж тогтоон хэргүүдийг шийдвэрлэсэн. Мөн 2017 онд бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохиох этгээд нь тогтоогдоогүй 72 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 52 хэргийг илрүүлж, илрүүлэлт 71.4 хувь байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулвал 7.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Тус газраас шалгасан хэргийн улмаас 475,7 сая төгрөгийн хохирол иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 299,4 сая төгрөг буюу 62.1 хувийг нөхөн төлүүлж, шүүхээс эд хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор сэжигтэн, яллагдагчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан болон хувьд ногдох 367,0 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн.

Замын цагдаагийн албаны чиглэлээр: Зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгуулах зорилгоор аймгийн 19 сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон аймгийн Тамгын газар, аймгийн авто зам засвар, арчлалт хариуцсан “Их богд зам” ХХК зэрэг албан

байгууллага, албан тушаалтанд 38 удаа албан мэдэгдэл бичиж, тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулсан талаар 28 албан мэдэгдлийн хариуг авсан.

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн “Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох тухай” А/737 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор тус тасгийн 3 цагдаа зохицуулагчийг 3 чиглэлд хуваарилан 9 сумдын тээвийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавиулан ажиллуулж, 19 сумдад очиж, иргэд малчдад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар сургалт, ярилцлага зохион байгуулж, сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж байгаа ажлыг шалган зааварчилж, гудамж замд эргүүл, шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж, хариуцлага ногдуулж ажиллалаа. Уг сургалтад нийт 19 сумдын 1200 иргэн оролцсон бөгөөд сургалтад хамрагдсан иргэдэд 1200 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, боршур, анхааруулга тараасан.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2017 оны эхний 9 сарын байдлаар Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 21 бүртгэгдэж, хэргийн улмаас 16 иргэний амь нас хохирч, 9 иргэн гэмтсэн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

Замын цагдаагийн тасгийн алба хаагчид Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт, шалгалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж зөрчсөн 4103 зөрчил илрүүлснээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 613, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 384, хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 345, хамгаалах бүс хэрэглээгүй 630, үзлэг оношлогоонд хамрагдаагүй болон бүрэн бус 330, бусад зөрчил 3247-ийг тус тус илрүүлж, нийт 9742594 жолоочид 280,591,700 төгрөгөөр бэлэн бусаар торгож, цаашид замын хөдөлгөөнд оролцох боломжгүй зөрчилтэй 1013 тээврийн хэрэгсэлийг түр саатуулж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн 625 захиргааны зөрчил шалгаснаас Зөрчлийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.7.3.1 дэх хэсэгт зааснаар 504 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 216,768.000 төгрөгөөр торгож, мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 14.7.5 дахь хэсэгт зааснаар 126 иргэнийг аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 236 иргэнд 124.096.000 төгрөгийн торгууль ногдуулж ажилласан.

Замын цагдаагийн тасгаас гудамж замд эргүүл, шалгалтыг тогтмол явуулж нэгдсэн шалгалтыг 20 удаа, хэсэгчилсэн шалгалтыг 22 удаа, аймгийн Авто тээврийн төв, Албан журмын даатгагчдын холбоо зэрэг байгууллагатай хамтран 73 /45 хоног дараалан/ удаа үзлэг шалгалтыг хот хоорондын зам болон орон нутгийн чанартай замуудад зохион явуулсан. Аймгийн хэмжээнд зохион явагдсан олон нийтийг хамарсан 8 арга хэмжээнд тус тасгаас 14 алба хаагч 86 хүн/цагийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: гудамж талбай, олон нийтийн газарт давхардсан тоогоор нийт 2136 алба хаагч 267 удаа, 17088 цаг өдөр, оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 267 удаа эргүүл шалгалтанд томилогдсон чиглэл маршрутын дагуу ажиллах хугацаанд 3045 тээврийн хэрэгсэл, 4274 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгаж ажилласан.

Захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол хүлээн авч шалган шийдвэрлэж, гудамж талбай, олон нийтийн газар болон ахуйн хүрээнд иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж танхайрсан зөрчил гаргасан 668 хүнийг шийтгэврээр 79,197,200 төгрөгөөр, 1468 хүнийг торгуулийн тасалбараар 50,214,200 төгрөгөөр, шүүхээр 24 иргэнийг 7-30 хоногийн хугацаанд баривчлуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд хууль, эрх зүйн талаар ухуулга, яриа таниулга, зөвлөгөө өгч ажилласан.

Тус газраас 2017 оны 9 сарын байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 19 нэгдсэн арга хэмжээ /улсын хэмжээнд зохион байгуулсан 8, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс зохион байгуулсан 11/, 35 хэсэгчилсэн арга хэмжээ, 25 удаа нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар Саатуулах байранд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, нийтийн хэв журам зөрчиж хүргэгдэн ирсэн 1179 хүнийг хүлээн авч, журмын дагуу бүртгэл судалгаанд авч албадан саатуулсан.

Саатуулах байранд ирсэн иргэдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон нийт 314 хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлсэн.

Зөрчлийн улмаас шүүхийн шийтгэврээр баривчлагдан ирсэн 290 хүнийг хүлээн авч, хувийн хэрэг нээн, эрүүл мэндийн үзлэгийг явуулж, журмын дагуу баривчлах шийдвэрийг биелүүлж ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа 141, уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага 11, өдөрлөг 30, уралдаан, тэмцээн 5, нийт 187 удаа зохион байгуулж 18630 иргэнийг хамруулсан байна. Энэ арга хэмжээг агуулгаар нь авч үзвэл: нийт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 55, хулгайлах гэмт хэргийн талаар 55, бусдын биед гэмтэл учруулах /танхайрах/ гэмт хэргийн талаар 1, зам тээврийн осол хэргийн талаар 38, гэр бүлийн хүчирхийллийн талаар 32, хүүхдийн гэмт хэргийн талаар 17, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 38, хар тамхи мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаар 2, хүн худалдаалах, цахим гэмт хэргийн талаар 4, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 187 удаа ухуулга, яриа, сургалт сурталчилгаа зохион байгуулсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ухуулга сурталчилгааны ажилд нийт 183 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсаны дотор төрийн байгууллага 124, аж ахуйн нэгж 7, их дээд сургууль коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 10, ерөнхий боловсролын сургууль 42 байна.

Энэ хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулахаар иргэн, хуулийн этгээдэд 147 мэдэгдэл өгч, 141 буюу 95,6 хувьд нь хариу авсан.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг банкны салбар, тооцооны төвүүдэд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг Хаан, Голомт, Төрийн, Капитал, Хас зэрэг 5 банкны 13 салбар, тооцооны төвүүдийн үйл ажиллагааг шалгаж, харуул хамгаалалт, аюулгүй байдлаа хэрхэн хангаж байгаа байдалд нь хяналт шалгалтыг явуулж, 150 ширхэг санамж тарааж ажилласан. Энэ хугацаанд цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагчдаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 төрийн байгууллага, 12 төрийн бус байгууллага, 86 аж ахуй нэгжийг мэргэжлийн удирдлагаар ханган ажилласан.

2017 оны 9 сарын байдлаар зөрчил гаргасан 1084 хүнийг шийтгэврээр 223,973,2 төгрөгийн, 4646 хүнийг торгуулийн тасалбараар 219,079,0 төгрөгийн, нийт 5730 зөрчилд 443,052,0 төгрөгийн торгууль ногдуулж, 1062 хүнийг саатуулах байранд саатуулж, 222 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчилж, 307 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 0,6-2 жил хүртэлх хугацаагаар хассан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан малчдын бүлэг холбоо, нөхөрлөл 19, өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 24, эцэг эхийн эргүүл ажилласан 14 сургууль, хамтарсан баг 24 үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 2412 иргэн хамрагдсан ба цагдаагийн байгууллагаас дээрх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 131 удаа зөвлөмж өгч хамтран ажиллаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон 21 иргэнийг цагдаагийн газрын даргын “Баярын бичиг”-ээр шагнаж урамшуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 18 гэмт хэрэг, 204 зөрчлийн дуудлага мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4.1 дэх /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/ зааснаар 101 хүнийг 7-30 хоногоор баривчлуулж, 680 албадан сургалтад хамруулан ажилласан.

2017 оны эхний 9 сарын байдлаар аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 18 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 нэгжээр буюу 25 хувиар буурсан.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар “Нэг цэгийн үйлчилгээний төв”-тэй хамтран саатуулах байранд баривчлагдсан 290 хүмүүжигч нарт 680 цагийн албадан сургалтыг зохион байгуулж ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 204 дуудлага, мэдээлэлд аюулын зэргийн үнэлгээ хийж, хохирогч нарын аюулын зэргийн үнэлгээг харгалзалгүй 151 дуудлага мэдээллийн хохирогчийг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д холбон зуучилж, хууль, эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө тусламжийг үзүүлэн хуулийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 204 хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийснээс өндөр эрсдэлтэй 18, дунд зэргийн эрсдэлтэй 65, бага зэргийн эрсдэлтэй 121 үнэлгээ хийгдсэн байна. Эдгээрээс Нэг цэгийн үйлчилгээний төвд 32 хохирогчийг /үүнээс эмэгтэй 16, хүүхэд 16/ Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбарын Нэг цэгийн үйлчилгээний төвд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалуулахаар байрлуулж, 151 хүнд сэтгэл зүйн тусламж үзүүлэхээр холбон зуучилж, ойр дотны хүн, хамаатан саданд 65 хүнийг хүлээлгэн өгч ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх, сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх, хамтарсан багийг сургах, чадавхжуулах чиглэлээр давхардсан тоогоор 342 цагдаагийн алба хаагч, 24 хамтарсан багийн 202 ажилтнуудад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж, үр дүнг тооцсон.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2017 оны 01/496, 4/104, 5/490, 5/62, 01/195, 4/662, 4/451, 4Б/311 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүр 5-23 заалт бүхий төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавьж ажилласнаар алба хаагчаас гаргасан сахилгын, ёс зүйн зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 3 нэгжээр буюу 10,7 хувиар буурсан.

ЦЕГ-ын даргын 2017 оны “Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 тоот албан даалгаврыг алба хаагч нарт сургалтаар орж, нотломж үйлдэн, хэрэгжилтийг хангах чиглэлээр 3 багц 23 заалт бүхий төлөвлөгөө гарган биелэлт эхний 9 сарын байдлаар 92,3 хувьтай дүгнэгдсэн.

Тус газрын алба хаагчдаас сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 121 алба хаагчаас бичгээр гаргуулан авсан. Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг тус байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүд 2 удаа зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 6 заалт бүхий төлөвлөгөө гарган тасаг, хэсгийн дарга, ахлах байцаагч нараас сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хариуцсан алба хаагч нартай ганцаарчилсан болон хэсэгчилсэн байдлаар 187 алба хаагчидтай 75 удаа уулзалт, 22 удаа сургалт зохион байгуулж, 74 удаа зөвлөгөө зөвлөмж, зааварчилгаа өгч, алдаа дутагдал гаргасан 22 алба хаагчтай ганцаарчлан уулзаж, ярилцан алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, 10 алба хаагчийг өвдөхөд нь эргэж, гачигдал тохиолдсон болон амьдрал ахуйд нь сэтгэл санаа, эдийн буюу мөнгөн туслалцаа үзүүлж, давхардсан тоогоор 67 алба хаагчийн ажлыг шалган зааварчилж, 61 алба хаагчдад үүрэг, даалгавар өгч биелэлтийг нь тооцон ажилласан.

Сахилгын зөрчил гаргасан 25 алба хаагчтай сэтгэл зүйн ярилцлага хийж, дахин алдаа дутагдал гаргахгүй байх талаар анхааруулж, гэр бүлийн асуудалтай байгаа 6, нийт 31 алба хаагчид болон тэдний гэр бүлийн 13 гишүүдтэй тус тус уулзаж, мэдээлэл аван, сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж дэмжлэг үзүүлсэн.

Мөн алба хаагчдын ажлын цаг ашиглалтын судалгааг гаргаж, ажлын цаг ашиглалт хангалтгүй, сахилга ёс зүйн зөрчилд холбогдох магадлалтай 12 алба хаагчидтай ганцаарчлан уулзаж, зөвлөгөө өгч ажилласан.

Алба хаагчдаас бие хүний “Темперамент” тодорхойлох судалгаа, сэтгэл ханамжийн болон сэтгэл санааны байдал тодорхойлох судалгааг улирал бүр авч, үр дүнг удирдлагуудад танилцуулж, тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Алба хаагчдын ерөнхий мэдлэгийн төвшинг дээшлүүлэх, өөрийгөө бусдад илэрхийлэх, ярих, илтгэх урлагийг эзэмшүүлэх, аливаа мэдээллийг олж, дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх зорилгоор өглөө бүрийн шуурхай яриан дээр дотоодын болон гадаад орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг, танин мэдэхүйн бусад мэдээлэл, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээлэл, сэтгэл зүйч Н.Наранбаатарын “Аз жаргалын набор” номыг танилцуулах хуваарь гарган алба хаагч нэг бүрээр хийлгэх ажлыг хэвшил болгон явуулснаар тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 402 алба хаагчдаас дээрх чиглэлийн мэдээллийг хийжээ.

Алба хаагчдыг сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн мэдлэг олгох, алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, ажлын амжилт гаргахад нь нөлөөлөх, стресс, бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх мэдлэгийг олгуулах, хэвшүүлэх зорилгоор “Уур бухимдлаа хянаж сурах нь”, “Хамт олны эв нэгдэл ба багийн ажиллагаа”, “Хүүхдийн сэтгэл зүйн онцлог”, “Сэтгэл зүйн хувийн онцлог харилцаанд нөлөөлөх нь” зэрэг сургалтуудыг орж, сэтгэл зүйн тест авч алба хаагчдын сэтгэл зүйн хувийн хэргийг баяжуулсан.

Хамт олны халуун дулаан уур амьсгалыг бэхжүүлэх, нөхөрсөг, найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс алба хаагчдын төрсөн өдрийн судалгааг гаргаж, тухай бүрт нь алба хаагчдын төрсөн өдрийг тэмдэглэн, баяр хүргэн дуу дуулах, бялуу хуваах, төрсөн өдөр нь ажлын өдрөөр тохиож буй алба хаагчид ажлын 4 цагийн цалинтай чөлөөг олгох зэргээр хамтдаа тэмдэглэж хэвшсэн. 3 дугаар улирлын байдлаар 22 алба хаагчийн төрсөн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Алба хаагчдыг гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өртөж хохирсон талаар мэдэгдэх, сан бүрдүүлэх, ашиглах”, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” зэрэг сэдвүүдээр 4 удаагийн 4 цагийн сургалтыг зохион байгуулж, 2 удаа баталгаа авсан. Алба хаагчдыг сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, стресс, бухимдал тайлах, сэтгэл хөдлөлөө хянаж зохицуулах, зөв амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх

зорилгоор алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдэд лектор багш Цэцэгсүрэнг урьж “Үнэ цэнэ” лекц, МУИС-ийн багш доктор Г.Цэрэн багшийн “Ажилдаа хандах хандлага”, МУИС-ийн профессор О.Мөнхбат багшийн “Төрийн үйлчилгээг төсөл хөтөлбөр хэлбэрээр хүргэх нь” лекцүүдийг уншуулсан нь албанд итгэх итгэл, урам зоригийг сэргээсэн чухал үйл явдал болсон.

2017 оны эхний 9 сарын байдлаар тус газрын алба хаагчдаас давхардсан тоогоор нийт 25 алба хаагч сахилгын зөрчил гарган арга хэмжээ авагдсанаас офицер 19, ахлагч 6 байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчид нийт бие бүрэлдэхүүний 17.4 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 3 нэгжээр буюу 10.7 хувиар буурсан.

Сахилга, ёс зүйн зөрчлийн хэлбэрээр авч үзвэл ажлын хариуцлага алдсан 13, ЭБШХ болон бусад хууль дүрэм зөрчсөн 4, архидан согтуурч, ажил тасалсан 2, Цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн 1, архидан согтуурсан 2, үүрэг даалгавар үл биелүүлсэн 1, бусад 2 зөрчил байна.

Үүнээс 11 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг бууруулах, 12 алба хаагчид сануулах, 2 алба хаагчийг Цагдаагийн албанд албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулж, тухайн байгууллагын дотоод хяналтаар 12, иргэд, байгууллагын мэдээллээр 11, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичгээр 1, гадны хяналтаар 1 зөрчлийг илрүүлсэн.

Сахилгын шийтгэл ногдуулах журам /код914/ын 914.51.а-д заасны дагуу сахилгын мэдээг хүснэгтийн дагуу нэгтгэж сар, улирал бүр ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажилласан.

Тус газарт ирүүлсэн аймгийн прокурорын 5 шаардлагыг бүртгэн, Хууль зүйн сайдын 2015 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу албаны шалгалт явуулж, шалтгаан нөхцлийг тодруулан газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хариуг бичгээр өгөх ажил хэвшил болсон. 2017 оны эхний 9 сарын байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын чиглэлээр гаргасан зөрчил дутагдлыг арилгуулахаар ирүүлсэн прокурорын шаардлагуудын шалтгаан нөхцөлийг судлан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагчдад 4 удаа 6 цагийн сургалт орж, тасгийн даргаас бичгээр 3 удаа зааварчилгаа хүргүүлж, “Сануулах хуудас” өгч дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллах талаар баталгаа авсан.

Тус газар нь 2017 онд зохиогдох албаны сургалтын нэгдсэн болон сэдэвчилсэн төлөвлөгөөг, тасаг бүр албаны сургалтын хуваарь гарган батлуулж, нийт бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн “Мягмар” гарагт онолын, “Баасан” гарагт бие бялдарын бэлтгэлжилтийн сургалтыг нэгдсэн байдлаар, тасгууд төрөл мэргэжлийн чиглэлээр долоо хоног бүр хуваарьт өдөр сургалтыг зохион явуулсан.

Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор санал асуулгыг алба хаагчдаас авч нэгтгэн, удирдлагад танилцуулан санал асуулгын дүнд үндэслэн 2017 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган батлуулсан.

Тус газраас ЦЕГ-ын даргын 2015 оны А/115 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах” /код 951/-ын хэрэгжилтийг хангах, Цагдаагийн алба хаагчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор “Албаны сургалтын хичээлийн шинэ жилийн нээлт”-ийг аймгийн Биеийн тамир спортын газар зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд алба хаагчдын дунд “Гар бөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулж, аймгийн Хөгжимт драмын театрын морин хуурч Г.Хишигбат, “Univers best songs” наадмын шилдэг оролцогч н.Анужин нар ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

ЦЕГ-ын даргын 2017 оны б/58 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2017 оны сургалтын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу энэ оны 3-9 дүгээр сард сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг тасгуудаас авч, нэгтгэн баталгаажуулж, ЦЕГ-ын Сургалтын төвд хүргүүлэн, хуваарийн дагуу 39 алба хаагч, офицер албан тушаал /ажлын байр/-ын сургалтад 4 алба хаагчийг тус тус хамруулсан.

ХСИС-ийн эчнээ 3 жилийн хөтөлбөрийн сургалтад 1, эчнээ 5 жилийн хөтөлбөрийн сургалтад 2 алба хаагч, “Улаанбаатар эрдэм” дээд сургуулийн эчнээ эрх зүйн ангид 5 алба хаагчийг хамруулсан.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар тус газрын даргаас баталсан сургалтын хөтөлбөр, цаг, сэдэв төлөвлөгөөний дагуу нэгдсэн хичээлээр алба хаагчийг хөгжүүлэх 9 удаагийн 9 цагийн сургалтад давхардсан тоогоор 630 алба хаагчдыг, мэдвэл зохих хууль тогтоомжийн 20 удаагийн 40 цагийн сургалтад давхардсан тоогоор 1640 алба хаагчдыг, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах 9 удаагийн 9 цагийн сургалтад давхардсан тоогоор 564 алба хаагчдыг хамруулсан.

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрөөс Баянхонгор аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн цогц хөгжил-түншлэл төсөл”-ийн хүрээнд төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх “Ажилтнуудын ажилдаа хандах хандлага, үнэт зүйлс”, “Төрийн үйлчилгээг төсөл, хөтөлбөр хэлбэрээр хүргэх нь” “Хяналт үнэлгээ, мониторинг хийхүй” сэдэвт сургалтыг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, хөдөө сумдад ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч цагдаа болон төвийн нийт 63 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, өөрийгөө болон бусдыг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чадвар эзэмшүүлэх, тусгай бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, дадлагжуулах зорилгоор ЦЕГ-ын Хамгаалалтын газраас мэргэжилтэнг урьж, 3 өдрийн сургалтад алба хаагчдыг бүрэн хамруулсан.

Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, эрх зүйн актын талаарх мэдээллийг алба хаагчдад шуурхай хүргэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан шинээр батлагдсан хуулиудыг таниулах, сурталчлах 5 өдрийн сургалтад хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий бүх алба хаагчдыг бүрэн хамруулж, гарын авлага, материалаар хангасан.

Сургалтын материаллаг баазын хувьд ЦЕГ-аас болон харъяа албад мэргэжлийн байгууллага, багш нараас гаргасан сургалтын аудио, видео бичлэг, кино, лекц, бодлого, сурах бичиг, гарын авлага, танилцуулга материал, зайн сургалтын материалуудыг тус тус ашиглан явуулсан.

Тус газар нь байгууллагынхаа 78 м² талбай бүхий өрөөг хурлын болон сургалтын танхим болгон ашиглаж, сургалтын үйл ажиллагаанд зөөврийн ACER компьютер 1 ширхэг, проектор 1 ширхэг, телескоп 1 ширхэг, зөөврийн дэлгэц 1 ширхэг, дижитал аппарат 1 ширхэг, шохойн хэрэглүүр бүхий 1 самбар ашигладаг. Албаны хуучин конторын барилгын 1 давхарт байрлах сургалтын танхимыг “Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг”-ийн төслийн 5,150,000 төгрөгийн санхүүжилтээр тохижилт, засвар үйлчилгээг хийж сургалтын орчинг бүрдүүлсэн. Сургалтын танхим нь 17 ширээ, 34 сандал, 1 проектор, 1 нөүтбүүк, 2 самбар бүхий техник хэрэгсэлтэй. Энэ хугацаанд албаны сургалтын зардалд нийт 608,000 төгрөгийг зарцуулсан.

Тус газраас орон нутгийн “Баянхонгор” “Хөгжлийн ертөнц Мазаалай” зэрэг телевизүүдтэй хамтран бусдын эд хөрөнгийг хулгайлах, тээврийн хэрэгслийн эд анги, хучлага алдагдахаас урьдчилан сэргийлэх, насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэгт холбогдох, түүнд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, химийн хорт болон аюултай бодисын хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 минутын нэвтрүүлэг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Мөн 12 төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, сэрэмжлүүлэг, гарын авлага бэлтгэж, “Нээлттэй өдөр” өдөрлөг арга хэмжээ бусад хуулийн байгууллагуудын хамтарсан нийтийг хамарсан арга хэмжээний үеэр нийт 3200 ширхэг зурагт хуудас, сэрэмжлүүлгийг иргэд олон нийтэд тарааж ажилласан.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 5 төрлийн богино хэмжээний видео бэлтгэн орон нутгийн 3 телевиз болон аймгийн төв талбайн лед дэлгэцээр иргэдэд хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан. Цагдаагийн албаны тухай хууль болон шинэчлэн батлагдсан хуулиудыг иргэдэд сурталчлах зорилгоор “Хөгжлийн ертөнц ТВ10” телевизээр шууд нэвтрүүлэгт оролцож “Цагдаагийн албаны тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийг иргэдэд сурталчилж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, асуултанд хариу өгч ажилласан.

Цагдаагийн газраас зохион явуулж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг www.bayankhongor.police.gov.mn сайтад 102, Facebook хаягт 142, ЦЕГ-ын үндсэн сайтад 13 удаа, шилэн дансны сайтад 81 удаа 2017 оны эхний 9 сард нийт 338 мэдээ, мэдээлэл оруулсан.

ЦЕГ-ын “Авлигаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2017 онд хийх ажлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэлээр 2 багц 13 заалт бүхий ажил, арга хэмжээний салбар төлөвлөгөөний төслийг гаргаж, биелэлтийг хангуулах чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Цагдаагийн Ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн даргын 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн

46/510 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг сурталчилан таниулах, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх 8 заалт бүхий ажлын төлөвлөгөөг гарган хөтөлбөрийг сурталчилан таниулах, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Хууль зүйн хэлтэстэй хамтран “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Авлигаас урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвүүдээр тус газрын 78 алба хаагчдад 1 удаагийн 1:30 цагийн сургалтыг зохион байгуулан, хэрэгжилт, үр дүнг тооцон ажилласан.

Алба хаагчдын 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан, 66 алба хаагчдыг хамруулан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг www.meduuleg.iaac.mn цахим хаягаар авч, мэдээллийг баталгаажуулан, холбогдох тайлан мэдээг заасан хугацаанд нь холбогдох газарт нь хүргүүлсэн. Тус газрын нийт 141 алба хаагчдаас авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар бичгээр баталгааг авч, нотломж үйлдсэн.

Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, авлига, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг ЦЕГ-ын 126 дугаарын тусгай утсаар 24 цагаар хүлээн авч байгаа талаар зурагт хуудсыг гарган орон нутгийн “Мазаалай” телевизээр сурталчилан Цагдаагийн газрын хүлээлгийн танхим, цагдаагийн хэсгийн байруудад байршуулсан.

Мөн АТГ-аас бэлтгэсэн авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг, төрийн байгууллага, албан тушаалны хүнд сурталын талаарх мэдээллийг 1800-1969 дугаарын утсаар хүлээн авч байгаа талаар видео бичлэгийг орон нутгийн телевиз, байгууллагын иргэдийг хүлээн авах танхимд байрлах зурагт самбарт мэдээллийг байршуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Авлигаас урьдчилан сэргийлэх, хөтөлбөрийг сурталчилан таниулах, авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр болон мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад зориулсан гарын авлага, боршурыг хийж алба хаагч, иргэдэд тараасан.

Иргэдийг хүлээн авах уулзалтын танхимд байгууллагын удирдлагууд болон тухайн өдрийн ёс журам сахиулах эргүүлүүд иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг шинэчлэн батлаж, иргэдээс Цагдаагийн байгууллагын болон алба хаагчдын үйл ажиллагаатай холбогдуулан 85 санал, хүсэлтийг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаар шийдвэрүүлэн ажилласан. Уг танхимд тасаг бүр өөрсдийн үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийг байршуулсан.

Байгууллагын хэмжээнд авлигагүй бүсийг нэвтрүүлэн ажилласнаар энэ хугацаанд алба хаагчдаас авлигын сэжигтэй тохиолдол болон авлига өгөхөөр оролдсон, санал болгосон тохиолдол бүртгэгдээгүй.

Дөрөв: Санхүүгийн бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Тус газар нь 2017 онд нийт 1,826,3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гуравдугаар улирлын байдлаар 1.326.5 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 38.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн нийт 1.364.7 сая төгрөгийн орлоготой, 1,354,8 сая төгрөгийн зардал зарцуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль, журам, зааврын дагуу зарцуулан ажилласан.

Тайлант хугацаанд цалингийн зардалд 1.204.7 сая төгрөг, НДШимтгэлд 21.8 сая төгрөг, тогтмол зардал болох Түлш халаалтын зардалд 11.4 сая төгрөг, гэрэл цахилгааны зардалд 5.7 сая төгрөг, цэвэр бохир усны зардалд 4.1 сая төгрөг, шатах тослох материалын зардалд 46.4 сая төгрөг, шуудан холбооны зардалд 4.1 сая төгрөг, алба хаагчдын дотоод албан томилолтын зардалд 9.6 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 8.9 сая төгрөг, урсгал засварын зардалд 16.4 сая төгрөг, хоолны зардалд 14.4 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 528.0 мянган төгрөг, эмийн зардалд 280.4 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 2.1 сая төгрөг, даатгалын хураамжийн зардалд 3.6 сая төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 750.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, нийт 1.354.8 сая төгрөгийн зардал гаргаж, 9.9 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй ажилласан.

2016 оны жилийн эцсийн байдлаар нэмэлт санхүүжилтийн данс, болон ахмадын сангийн дансны үлдэгдэл 9,621,3 мянган төгрөгийг сангийн яам татан төвлөрүүлснийг авлагаар бүртгэснийг, 6 сарын 15-нд Сангийн яамнаас татан төвлөрүүлсэн орлого буцаан олгосноор авлага бүрэн барагдсан.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар Цагдаагийн ерөнхий газрын авто баазаас Elentra маркын авто машин, УАЗ-469 маркын автомашин, Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн орлогоос тусгай тоноглолтой 1,6 сая төгрөгийн өртөгтэй мотоцикль, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 1,3 сая төгрөгийн зургийн аппарат, 1,0 сая төгрөгийн буйданг тус тус хүлээн авч хөрөнгийн орлогод авч бүртгэсэн.

Тайлант хугацаанд ЦЕГ-ын Хангалт үйлчилгээний төвөөс 2.7 сая төгрөгийн тээврийн хэрэгслийн шилэн наалт, хурд, улсын дугаар хэмжигч багаж хэрэгсэл, 757.5 мянган төгрөгийн албан тоотын бланкууд, авто баазаас 1.9 сая төгрөгийн тусгай дуут гэрлэн дохио, 125.0 мянган төгрөгийн аккумулятор, 376,0 мянган төгрөгийн шатах тос, тосолгооны материал, санхүү аж ахуйн албанаас 507.5 мянган төгрөгийн үнэт цаас, галт зэвсгийн гэрчилгээ, 5.0 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 1.3 сая төгрөгийн энгэрийн камер, гэрэл маяг, сургалтын албанаас 500,0 мянган төгрөгийн сургуультай нохойг тус тус хүлээн авч орлогоор хүлээн зөвшөөрч, үндсэн хөрөнгө болон материалын тусгай дансанд бүртгэсэн.

2017 оны урсгал засварын төсөвт Жаргалант сум дахь цагдаагийн бичил байр /кобан/-ыг засварлах ажилд 7.8 сая төгрөг батлагдсаныг Зэвсэгт хүчний 0339 дүгээр ангиар батлагдсан зураг төсвийн дагуу хийж гүйцэтгүүлэн, ажлын гүйцэтгэл, танилцуулгыг Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн ажилласан.

Мөнгөн хөрөнгө, бараа материал, шатахууны тайлан, холбогдох журналуудыг тус бүрд нь хөтөлж, няраваар сар бүр тайлан гаргуулан, тулган шалгаж баталгаажуулан ажилласан. Энэ оны 1, 2 дугаар улирлын санхүүгийн тайлан балансыг гаргаж, газрын

даргаар баталгаажуулан ЦЕГ-ын САААлбанд хүргүүлж, 3 дугаар улирлын санхүүгийн тайлан балансыг гаргахаар бэлтгэж байна.

Мөн тус газрын түүхт 75 жилийн ой, аймгийн Засаг даргын тамгын газрын А/82 тоот захирамжаар зохион байгуулагдсан “Бүтээлч-санхүүч” аяны хүрээнд аймгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, нярав нарын санхүүгийн хууль тогтоомж, журмын мэдлэгийг бататгах, хэрэгжилтийг сайжруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажлын дадлага туршлагаа солилцох зорилгоор өөрийн байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагааны талаарх үзүүлэх сургалтыг 2017 оны 06 сарын 07-ны өдөр Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын хүндэтгэлийн танхим, сургалтын зааланд 2 үе шаттайгаар зохион явуулсан.

Төсвийн орлого зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, төсвийн орлого ба зарцуулалтын мэдээ, 2016 оны санхүүгийн тайлан, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын байгууллагаас Цагдаагийн газрын санхүүгийн тайлан балансад үзүүлсэн аудитын итгэмжлэл, 2017 оны батлагдсан төсвийн хуваарь, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулахтай холбогдон гарч байгаа тушаал, худалдан авах үйл ажиллагааны тайлан, гэрээ зэрэг мэдээ мэдээллүүдийг цахимаар болон файл хэлбэрээр нийт 79 төрлийн 1,175,8 сая төгрөгийн орлого, 130,5 сая төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийг шилэн дансны <http://shilendans.gov.mn/> сайтад байршуулсан. Мөн Цагдаагийн газрын иргэдийн хүлээлгийн танхимд байрлах мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллүүдийг тогтмол байршуулж хэвшсэн.

2017 оны батлагдсан төсвөөс 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасны дагуу 3 нэр төрлийн бараа материал худалдан авахаар бэлтгэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/29 тоот албан тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулсан.

”Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2017 онд 82,884,0 мянган төгрөгийн үнийн санлаар худалдан авах шатахуун тослох материалыг нийлүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг аймгийн “Орон нутгийн өмчийн газар”-тай хамтран зохион байгуулж 2017 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр нээж НИК ХХК-ны Баянхонгор аймаг дахь салбартай гэрээ байгуулан, шатахуун тос, тослох материалуудыг худалдан авч албан үүрэг гүйцэтгэхэд зарцуулсан.

Тайлант хугацаанд нийт 1410 ширхэг шийтгэвэрээр 168,8 сая төгрөгийн, 1366 ширхэг торгуулийн хуудсаар 6,7 сая төгрөгийн орлогуудыг орон нутгийн хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн ажилласан.

Саатуулагдсан болон баривчлагдсан хүмүүсийн төлбөр төлөлтөнд хяналт тавьж, сар бүр тайланг хүлээн авч харилцахын хуулгатай тулган баталгаажуулж нийт 11,1 сая төгрөгийг байгууллагын 100030012001 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан.

Монгол банкны гэрээт цагдаагаар ажиллаж байгаа 4-н алба хаагчын цалин хоолны зардлын тооцоог гаргаж, Монгол банкинд хүргүүлэн шийдвэрлүүлж, 37,9 сая төгрөгийг байгууллагын 100030012001 тоот дансанд төвлөрүүлсэн.

Тав: Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

ЦЕГ-ын даргын 2016 оны Б/302 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын ажиллах урам зориг, ар гэртээ зарцуулах цаг завьг нэмэгдүүлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, дэлгэрэнгүй судалгаатай болох зорилгоор 18 асуулт бүхий санал асуулгыг алба хаагч, тэдний гэр бүлийн гишүүдээс авч нэгтгэн, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын удирдлагаас сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын амьдрал ахуйтай танилцаж, алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах, байрны засвар үйлчилгээг шийдвэрлүүлэхээр Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон 6 сумдын Засаг дарга нарт хүсэлт хүргүүлснээр 3 алба хаагчийн гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангасан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор барих 40 айлын орон сууцанд 15 алба хаагчийг, олон жил тогтвор суурьшилтай, хөдөө сумдад ажилласан 10 алба хаагчид аймгийн төвд эзэмшлийн газар өмчлүүлэх асуудлыг тусгуулж шийдвэрлэхээр тогтсон.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажил амралтын цагийг зохицуулах, ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Эрдэнэцогт сумын нутагт байрлах “Өвгөн жаргалант” амралтын газарт “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-тай гэрээ байгуулж, алба хаагчдын гэр бүлтэйгээ амрах нөхцөл боломжийг хангах үүднээс амралтын байрыг засаж тохижуулан ЦЕГ-ын “Сүүж-уул” сувилалын газар 5 ахмад настанг, “Шаргалжуут” рашаан сувилал, “Өвгөн жаргалант” амралтын газарт алба хаагчдын 85 хувь нь амарсан.

Мөн 2017 оны дотоодод аялах азтангаар шалгарсан 10 албан хаагч, байгууллагын ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Бүтээлч ажил-75” аянд идэвхтэй оролцож хамт олноо манлайлсан 12 алба хаагчийг Говь-Алтай аймгийн “Ээж уул”, “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийг Баацагаан сумын “Бөөнцагаан нуур”, Голомт банкнаас зохион байгуулсан аянд азтангаар шалгарсан 1 алба хаагчийг “Улан-Үдэ” хотод нийт 23 алба хаагчийг тус тус гадаад дотоодын аялалд аялуулсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 30 алба хаагчийг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд бүрэн хамруулж, бүх төрлийн нарийн шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулан, эмчилгээ шаардлагатай 5 алба хаагчийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлсэн.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын харъяа “Өлзий мандал” эрүүл мэндийн төвтэй

хамтран нийт алба хаагчдыг “Элэгний В,С вирус”-ын шинжилгээнд хамруулж, “Хепатит В вирус”-ын дархлаажуулалтын 3 дахь тунд нийт 86 алба хаагч хамрагдаж бүрэн хамрагдсан.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын харъяа “Оточ номгон” эрүүл мэндийн төв, “Наянбулаг ганга” эмийн сантай хамтран 2017 оны 05 дугаар сарын 18-ний өдөр тус газрын эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг 31 алба хаагчийг “Хеликобактерийн шинжилгээнд, “Антибиотикийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалтанд 56 алба хаагчийг хамруулж, 8 алба хаагч хеликобактертай гарсан ба эдгээр 8 алба хаагчид хөнгөлөлттэй эмийн жороор эм олгосон.

Аймгийн Засаг даргын 2017 оны захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын алба хаагчидтай хамтран “Эрчүүдээ хайрлая” аяны хүрээнд тус газрын эрэгтэй 65 алба хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.

Улаанбаатар хотын “Хаппи Веритас” хувийн эмнэлгийн эмч Лхагвадулам ирж 2 алба хаагчийн элэгний В вирусыг идэвхжил тодорхойлуулах, тоолуулах үзлэг шинжилгээнд хамруулж, нийт 18 алба хаагчийг эхо, бүх төрлийн хавдрын шинжилгээ, хелокобактерийн шинжилгээ, үе мөчний үрэвслийн шинжилгээ, элэгний В,С,Д вирус тодорхойлуулах шинжилгээнд хамруулсан. “Супперосор” өрхийн эмнэлэгтэй хамтран 53 алба хаагчийг тарваган тахлын вакцинд хамруулсан. Алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоог тогтмол явуулснаар эхний 9 сарын байдлаар эрүүл мэндийн шалтгаанаар акт авсан хаагч байгаа нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 18,5 хувиар буурсан байна.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран ажиллах гэрээ байгуулан долоо хоног бүрийн “Баасан” гарагт нийт алба хаагчдыг спортоор хичээллэх боломжийг хангасан.

“Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд алба хаагчид гэр бүлийнхээ хүнсний хэрэгцээнд зориулан хавар тариалсан хүнсний ногоогоо хурааж, 6 тн орчим ургац хурааж, алба хаагч тус бүрд 50 кг төмс хүнсний ногоо өгч “Ургацын баяр”-аа тэмдэглэлээ. Уг арга хэмжээний хүрээнд хамт олны халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөгжөөнт буухиа” тэмцээн зохион байгуулж, Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс ургацын дээжээр хоол хийж хамт олноо дайлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор алба хаагчид тэдний гэр бүлийн гишүүдийг оролцуулан 5 км-ын “Явган аялал”-ыг Өлзийт сумын “Бийрийн баг” Баянзүрхийн хийдэд зохион байгуулсан нь алба хаагчдын стресс, ядаргааг тайлсан үр дүнтэй арга хэмжээ болсон.

Энэ оны эхний 9 сард бие бүрэлдэхүүний дундын сангаас алба хаагчдын нийгмийн асуудал, соён гэгээрүүлэх ажилд нийт 8.289.000 төгрөгийг тус тус зарцуулсан. Тасаг албаад сар бүр хамт олны хурлыг зохион байгуулж, алба хаагчдынхаа ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн давхардсан тоогоор 129

алба хаагчийн албан тушаалын цалинг нэмж, 60 алба хаагчийн сарын үндсэн цалинг тодорхой хувь хэмжээгээр хасаж олгосон.

Цагдаагийн газрын алба хаагчдын хамт олны “Дундын сангийн журам”-ын 6-д зааснаар “Зайлшгүй шаардлагатай тохиолдолд сард 3 хүртэл алба хаагчид 1 сарын хугацаатай 500000 хүртэлх төгрөгийг 3 хувийн хүүтэй дундын сангаас гаргаж, дундын санд хуримтлал бүрдүүлэх” гэсэн заалтын дагуу 24 алба хаагчид 4.178.000 төгрөгийг сарын 3 хувийн хүүтэй зээлүүлсэн.

Цагаан сарын баярын хүлээн авалт, хүндэтгэлийн арга хэмжээ, ахмадуудын гарын бэлгэнд нийт 1.540.0 мянган төгрөг, 2 ахмадын буяны ажилд 216.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг тус тус ахмадын сангаас олгосон.

Мөн ердийн галлагаатай хашаа байшин болон гэрт амьдардаг 12 алба хаагчдад тус бүр 1 тн нүүрсийг хөнгөлөлттэй үнээр, 10 ахмад настанд тус бүр 1 тн нүүрсийг үнэгүй олгосон. Цагдаагийн газрын “Сүүж-Уул” сэргээн засах сувиллын газар 4 ахмад, ОХУ-ын Улаан үүд хотод 1 ахмадыг эмчилгээ сувилгаа хийлгэх зардалд нийт 580.0 мянган төгрөг, 2 ахмадын буяны ажилд 216.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, Шаргалжуут рашаан сувилалд 3 ахмадыг амраах зардалд 650,0 мянган төгрөг, 75-н жилийн ойд зориулан гаргасан байгууллагын түүхийг харуулсан зургийн цомогон номны үнэнд 600,0 мянган төгрөгийг тус тус ахмадын сангаас зарцуулсан.

2017 оны гадаадад аялах азтангаар шалгарсан 10 албан хаагч, цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 2 ахмад настныг ОХУ-ын “Улан-Үдэ” хот, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан тус газраас эмэгтэй 12 алба хаагчдыг “Бээжин” хот, 2016 оны ажлын үр дүнгээр А үнэлэгдэж, байгууллагын “Хөдөлмөрийн аварга”-аар шалгарсан 10 алба хаагчийг БНХАУ-ын Өвөр монгол өөртөө засах орны Хөх хот, Ордос аймгуудаар нийт 32 алба хаагчийг тус тус аялуулсан.

ЦЕГ-ын даргын 2017 оны баталсан “Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах талаар хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд тус газраас 7 бүлэг 24 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Байгууллагын албаны нууцлал, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар 2 удаа гэнэтийн шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг удирдлагад танилцуулан, зөрчлийг арилгах чиглэлээр зааварчилгаа өгсөн.

Мөн алба хаагчийн эрх чөлөөнд халдсан, хууль ёсны шаардлагыг нь эсэргүүцсэн, ажил үүрэгтэй нь холбогдуулан өөрийг нь болон гэр бүлийн гишүүдийг нь доромжилсон, заналхийлсэн үйлдэл бүрийг тусгайлан бүртгэлд авч, тухай бүр удирдлагад танилцуулан шуурхай шалгуулах, бүртгэгдсэн тохиолдол бүрийг тухайн өдрийн ёс журмын эргүүлүүд хяналт тавьж, нөхцөл байдлыг баримтжуулах, тасгийн дарга нар алба хаагчидтайгаа уулзаж, ажлын зааварчилгаа, зөвлөгөө өгч, албаны итгэл үнэмшил олгох сэтгэл зүйн ярилцлага хийж байх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авсан.

Эхний 9 сарын байдлаар байгууллага, алба хаагчийн аюулгүй байдалд халдсан, мэдээ, мэдээлэл алдагдсан тохиолдол бүртгэгдээгүй.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

ЦЕГ-аас 2017 онд хэрэгжүүлэх “Гүйцэтгэл сайжруулах” төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын хэмжээнд 5 багц 18 заалт бүхий төлөвлөгөө гарган, байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах чиглэлээр мэдээллийн санд баяжилт хийж, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хагас жилийн байдлаар тооцоход 78,8 хувьтай дүгнэгдсэн.

Алба хаагчдыг гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, “Алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өртөж хохирсон талаар мэдэгдэх, сан бүрдүүлэх, ашиглах”, “Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх” “Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн удирдлага” зэрэг сэдэвт сургалтад давхардсан тоогоор 514 алба хаагчдыг хамруулсан.

Цагдаагийн газрын эрсдэлийн үнэлгээг газрын даргын тушаалаар томилогдсон Эрсдэлийн үнэлгээ хийх орон тооны бус багаас 2017 онд нийт А бүлгийн Төсөв санхүүгийн 12, Б бүлгийн Үйл ажиллагааны 44, В бүлгийн Нийцлийн буюу эрх зүй зохицуулалтын 8, Г бүлгийн Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй зүйлсийн 6 эрсдэл нийт 70 эрсдэлийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан. Эрсдэлд тооцон бүртгэгдсэн ямарч тохиолдолд гарч байдаг, гарсан ч тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаанаас хамаарахгүй гадны хүчин зүйлсээс болж гардаг 26 эрсдэл /inherent/, байгууллага дотооддоо удирдаад арилгаж, бууруулж, урьдчилан сэргийлж болох 44 эрсдэл /residual/ байна.

Эрсдэлийн санд баяжилт хийн, байгууллагын эрсдэлийг тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. Цаашид эрсдэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлага зохион байгуулж, гарсан санал, санаачлагыг нэгтгэн 2017 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээг авах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус газрын тасаг, хэсгийн дарга нараас Монгол Улсын Хууль зүйн сайдын 2015 оны 238 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд албаны шалгалтыг тал бүрээс нь бүрэн гүйцэт, бодитой явуулж, алба хаагчийн гаргасан зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хэвшсэн. Энэ оны 3 дугаар улиралд тус газрын 42 алба хаагчдад холбогдуулан 33 удаа албаны шалгалт явуулж, гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, эрх бүхий алба хаагчдаас дахин зөрчил, дутагдал гаргахгүй байх зорилгоор 16 алба хаагчдад “Сануулах хуудас” өгч, хариуцсан алба хаагчдад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тасгийн дарга нарт хугацаатай үүрэг хүргүүлж, 3 тасгийн даргад сахилгын шийтгэл ногдуулсан.

Долоо: Дүгнэлт

Тайлант хугацаанд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр улсын хэмжээний 12, цагдаагийн газрын хэмжээнд 14 нэгдсэн арга хэмжээ, 38 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 71 удаагийн нэгдсэн үзлэг шалгалтад гарч ажилласан ба 141 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 210 удаа уулзалт ярилцлага, 30 удаагийн өдөрлөг, 5 удаа уралдаан тэмцээн зохион байгуулж, нийт 257 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18870 иргэнийг хамруулж ажилласнаар гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 141 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 11 удаа уулзалт ярилцлага, 30 удаагийн өдөрлөг, 5 удаа уралдаан тэмцээн зэрэг нийт 187 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 18630 иргэнийг хамруулж ажилласнаар согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 10 хувь, гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 23 хувиар тус тус буурч, зөрчлийн илрүүлэлт 48,4 хувиар өссөн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, тэргүүн дэд дарга, дэд дарга нараас алба хаагчдын сахилга, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр ирүүлсэн 2017 оны 01 тоот албан даалгавар, 4/104, 5/490, 5/62, 01/195, 4/662, 4/451, 4Б/311 тоот албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тус бүр 5-16 заалт бүхий төлөвлөгөө гарган, биелэлтэд хяналт тавин ажиллаж, ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 8 заалт бүхий баталгааг 121 алба хаагчаас бичгээр гаргуулан авч, сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг тус газрын “Ёс зүйн зөвлөл”-ийн гишүүд 2 удаа зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 6 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласнаар алба хаагчаас гаргасан сахилгын, ёс зүйн зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 3 нэгжээр буюу 10,7 хувиар буурсан.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд давхардсан тоогоор 345 алба хаагчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд үнэгүй хамруулж, 15 алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр орон сууцанд хамруулахаар, 10 алба хаагчид өмчлөлийн газар олгуулах асуудлыг шийдвэрлэж, ажиллах урам зоригийг сэргээх, стресс ядаргааг тайлах зорилгоор 32 алба хаагчийг гадаадад аялуулж, 3 сумын цагдаагийн бичил байр /кабон/-ы засварыг хийлгэснээр алба хаагчдын ажиллах урам зориг нэмэгдсэн.

Цаашид авах арга хэмжээний санал:

Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дарагдуулалгүй бүртгэлд оруулж, дуудлага, мэдээллийн дагуу шуурхай очиж, хойшлуулшгүй ажиллагааг бүрэн дүүрэн, шуурхай хийж хэргийг халуун мөрөөр нь илрүүлэхэд багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад тасгийн дарга, ахлах нараас тавих хяналт, алба хаагчидтай ажиллах ажиллагааг сайжруулж, Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай бүрэн дүүрэн, процессийн зөрчилгүй явуулах

Шинэчлэгдэн батлагдсан хуулиудыг хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, эрх бүхий алба хаагчдыг дадлагажуулах, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Б.БАТБИЛЭГ

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД